

# Жендэрт суурилсан хүчирхийлэл ба хэвлэл мэдээллийн хэрэгсэл

ХЭҮТ-хөтөлбөрийн менежер

М.Мөнхсаруул

# Агуулга

- Хүчингийн гэмт хэрэг
- Хүн худалдаалах гэмт хэрэг
- Хэвлэл мэдээллийн өнөөгийн хандлага
- Хохирогчид хэрхэн нөлөөлдөг
- Нийгэмд хэрхэн нөлөөлдөг
- Анхаарах асуудал

# Хүчингийн гэмт хэрэг

- Хүчингийн гэмт хэрэг нь бэлгийн хүчирхийллийн нэг төрөл
- Бэлгийн хүчирхийлэл нь хүч хэрэглэхээс гадна хууран мэхлэх, итгэл эвдэх, дарамт шахалт үзүүлэх, айлган сүрдүүлэх аргаар үйлдэгддэг
- Хүчиндэх гэмт хэрэг нь зөвхөн нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг биш

# үргэлжлэл

Хүний халдашгүй, чөлөөтэй, аюулгүй, байх эрхийг зөрчсөн зөрчил төдийгүй хүч чадал, эдийн засаг, албан тушаал, зэрэг өөрт байгаа ямар нэгэн давуу байдлыг ашиглаж, эрх мэдлээ мэдрэх гэж үйлдэгддэг гэмт хэрэг юм.

# үргэлжлэл

- Хүний бие махбод, сэтгэл санаа, эрүүл мэндийн бүрэн бүтэн байдал, өөртөө итгэх итгэл, нэр төр, өөрийнхөө сэтгэл санаа, бие махбодоо өөрөө мэдэх, хянахын эсрэг үйлдэгдэж буй гэмт хэрэг юм.

# Эрүүгийн хууль:

## 126 дугаар зүйл. Хүчиндэх

- 126.1.Хохирогчид хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, эсхүл бусдын биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулан хурьцал үйлдсэн бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

# Хүн худалдаалах гэмт хэрэг

- Хүний мөлжих зорилгоор хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хүч хэрэглэх, эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эмзэг байдлыг нь ашиглах, эсхүл өөр этгээдийг хяналтдаа байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр хийж буюу ашиг олгон хахуульдах зэрэг аргаар хүмүүсийг урвуулан элсүүлэх, тээвэрлэх дамжуулах, нуугдуулах буюу хүлээж авах үйлдлийг **“Хүн худалдаалах”** гэнэ.

## Үргэлжлэл

- **“Мөлжих”** гэдэг нь бусдын биеийг нь үнэлүүлэх, буюу бэлгийн харьцаанд оруулан мөлжих бусад хэлбэрүүд, албадан ажиллуулах буюу үйлчлүүлэх, боолчлол буюу боолчлолтой төсөөтэй заншил, эрх чөлөөгүй байдгах буюу эрхтнийг нь авах зэргийг ойлгоно.

# Эрүүгийн хууль:

- 113 дугаар зүйл. **Хүн худалдаалах**

113.1.Ашиг олох буюу мөлжих зорилгоор хүн худалдаалахдаа хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, хууран мэхэлсэн, эмзэг байдлыг нь далимдуулсан, түүнчлэн бусдыг элсүүлсэн, тээвэрлэсэн, дамжуулсан, орогнуулсан, хүлээн авсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ

# Хэвлэл мэдээллийн өнөөгийн хандлага

- Хохирогчыг илт буруутгадаг
- Хохирогчын нэр, хаягыг дурддаг
- Хохирогч болон түүний гэр бүлийн талаарх мэдээлэл /ажил, мэргэжил гм/
- Гэмт хэрэгтэн хэргийг хэрхэн үйлдсэн талаар шат дараалсан бүх үйлдлийг нь дүрсэлж мэдээлдэг
- Нийгэмд тухайн гэмт хэргийг мэдээлэхдээ сенсаац болгох зорилгоор бичдэг

- Тухайн мэдээлсэн гэмт хэргийн талаар эргээд сурвалжлага, мэдээлэл хийдэггүй, гэмт хэрэгтэн хэрхэн шийтгэгдсэн гм
- Мэдээллийн эх сурвалжаа тодорхой дурддаггүй
- Тухайн гэмт хэрэг нь шүүхээр эцэслэн шийдэгдээгүй байхад мөрдөн байцаалтын явцын талаар, зарим нэг фактуудыг хамаагүй олон нийтэд дэлгэдэг
- Хохирогчыг бие үнэлэгч гэж шууд дүгнэлт өгдөг

- Тухайн гэмт хэргийн онцлог байдал, мөн чанарын талаар ерөнхий ойлголтгүй байдгаас ёс зүйн алдаа гаргадаг /хаана хамгаалалтанд авсан талаар гм/
- Тухайн гэмт хэргийн талаарх эрх зүйн орчин ямар байгааг судлах, энэ талаар өөрчлөлт бий болгоход дуу хоолой болж чаддаггүй
- Хохирогчын аюулгүй байдал, эрсдлийн түвшинг анхаарч үздэггүй

# Хохирогчид үзүүлэх нөлөө

- Нэр төр, алдар хүнд нь гэр бүлдээ, найз нөхөд, нийгэмд
- Ялгаварлан гадуурхагддаг
- Хохирогч болон түүний гэр бүлийнхэнд сэтгэл зүйн хүнд дарамтанд ордог
- Хохирогч болон түүний гэр бүлийнхэн эдийн засгийн хүнд байдалд ордог

- Ажилгүй, сургуулгүй болдог
- Оршин суугаа газраасаа нүүх, олон нийтээс нуугдах нөхцөлд хүргэдэг
- Аюулгүй байдал нь алдагддаг
- Мэдүүлгээсээ буцахад хүргэж, гэмт хэрэгтэн ял завшдаг

# Нийгэмд үзүүлэх нөлөө

- Гэмт хэргийн хохирогч эмэгтэйчүүд, охидууд л байдаг
- Эмэгтэйчүүд охидуудыг ингэж болдог юм байна
- Хохирогч өөрөө буруутай байдаг/эмэгтэйчүүдийг буруутгах хандлага/
- Гэмт хэрэг үйлдэгдэх сэдлийг төрүүлдэг
- Хохирогч, түүний гэр бүлийн гишүүдийг ялагварлан гадуурхах үзэл нэмэгддэг

- Гэмт хэргийн шалтгаан, гэм бурууг **архи** гэсэн ойлголт бий болдог
- Энэ төрлийн гэмт хэргийг зөвхөн сэтгэцийн өвчтэй хүн эсвэл багадаа хүчирхийлэлд өртөж байсан хүн үйлддэг
- Энэ төрлийн гэмт хэргийн хохирогч бол бузартсан
- Хохирогчыг гэмт хэргийн газраас зугтаагүй учраас өөрөө хүссэн гэж буруутгах

# Анхаарах асуудал

- Хүний эрхийн талаар ойлголт, мэдлэгтэй байх
- Жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх ойлголт мэдлэгтэй байх
- Тухайн гэмт хэргийг шийдвэрлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх эрх зүйн орчин ямар байгаа бодит байдлын талаар мэдлэгтэй байх

- Тухайн гэмт хэргийн онцлог байдал, нийгэмд үзүүлэх аюулын талаар мэдээлэлтэй байх
- Хохирогч, гэрчийн аюулгүй байдлын түвшин, хэрэгцээг мэдрэх
- Хүний эрхийн талаархи хууль тогтоомжийг тухай мэдээллийг өргөнөөр түгээх

- Мэдээллээс болж учирч болзошгүй хор хохирлыг урьдчилан тооцоолж, багасгах
- Аль болох зураг, илт танигдахуйц шинж тэмдгийг нийтлэхгүй байх
- Ярилцлагад өөр нэр ашиглах
- Хохирогчийг хүсвэл өөрийн үзэл бодлоо илэрхийлэх боломж олгох, дэргэд нь хөндлөнгөөс нөлөөлөхүйц хүн байлгахгүй байх

- Бэлгийн хүчирхийллийн хэрэгт сексийн талаар ярихгүй байх
- Зураг авахдаа өөрт нь мэдэгдэх, хүүхэд бол насанд хүрэгчээс заавал зөвшөөрөл авах
- Бусдын нэрийг зээлж, өмнөөс нь өөрийн үзэл бодлоо илэрхийлэхгүй байх

- Хүний эрхийг зөрчихийн эсрэг анхаарлаа хандуулж, тэдний аюулгүй байдлыг хангах, илрэх илрэл, сөрөг үр дагаврыг олон нийтэд ойлгуулах, маргаан хэлэлцүүлэг өрнүүлэх
- Хэвшмэл ойлголтоос зайлсхийх, сенсаци хөөцөлдөхгүй байх

## Эцэст нь:

- Тулгамдсан асуудал
- Яаж шийдвэрлэж байна, яаж шийдвэрлэх вэ, шийдвэрлэх ямар сонголтууд байна, ямар өөрчлөлтийг хийх шаардлагатай вэ?
- Шаардлагатай өөрчлөлт хийх эрх мэдэл хэнд байна вэ?
- Шийдвэр гаргагчид өөрчлөлт хийж чадахгүй бол хэн шахалт үзүүлж болох вэ?
- Тэдэнд ямар мэдээллийг хүргэвэл таны, та бүхний хүссэн шийдвэрийг гаргах вэ?

## ■ Ашигласан материал:

- *Баримтын хуудас “Монгол дахь бэлгийн хүчирхийлэл болон хүчиндэх гэмт хэргийн нөхцөл байдал эрх зүйн зохицуулалт” ХЭҮТ, Хүний эрх хөгжил төв, Иргэдийн альяанс төв хамтран боловсруулсан*
- *Палермогийн протокол 2000*
- *Монгол улс, Эрүүгийн хууль 2000*
- *Монгол улс, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль*
- *Gender in Media Education and Journalism Training, Southern Africa Report, Gender Links, 2010*
- ***“Communicating for Change: Getting Voice, Visibility and Impact for Gender Equality” is partly funded by the “MDG3 Fund: Investing in Equality”, set up by the Dutch Minister for Development Cooperation.***

■ **Анхаарал тавьсанд баярлалаа**